



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/149

Батноров сум

**Газар эзэмшүүлэх эрх шилжүүлэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу иргэн Балдан овогтой Наранхандын Бэрх 7 дугаар багийн Домик-3 хаягт байрлах Хүнсний ногооны зориулалттай 2304011651 нэгж талбарын дугаар бүхий 1000 квадрат метр газрын эзэмших эрхийг иргэн Чойжил овогтой Энхбаатард шилжүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Ч.Энхбаатард үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Т.Очирбат/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны а/120 тоот захирамж болон 000557223 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР

230423347